

Огноо:	2025 оны 08 дугаар сарын 08 -ны өдөр
Зээлийн дугаар ба нэр:	L3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл
Гэрээний дугаар ба нэр:	CW02: Замын-Үүд Чөлөөт бүсээс сумтай холбогдох хоёр эгнээтэй 1.2 км замын ажил
Тендер хүлээн авах эцсийн хугацаа:	2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас **Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийг** санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээнүүдийн төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.

2. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт заасны дагуу нэг гэрээ байгуулахаар тендер ирүүлж болно. Тендерт оролцогчид үнийн хөнгөлөлт санал болгохыг зөвшөөрөх ба уг үнийн хөнгөлөлтийг тендерийн маягтад тусгасан байна.

3. Монгол Улсын Шадар сайдын ажлын алба (“Захиалагч”) нь эрх бүхий тендерт оролцогчийг **CW02: Замын-Үүд Чөлөөт бүсээс сумтай холбогдох хоёр эгнээтэй 1.2 км замын** (“Ажил гэх”) ажлын барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

4. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны *нэг үе шаттай: нэг дугтуйт* горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендерт оролцогчдод нээлттэй байна.

5. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендерт оролцогч оролцоно. Үүнд:

- Сүүлийн 5 (2020, 2021, 2022, 2023, 2024) жилд амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **₮10,000,000,000** (Арван тэр бум төгрөг) төгрөгөөс доошгүй байна.
- Сүүлийн 3 жилд (2022, 2023, 2024) хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ: **₮12,000,000,000** (Арван хоёр тэрбум төгрөг) байна.

6. Зам тээврийн яамны дараах тусгай зөвшөөрлүүд шаардлагатай. Үүнд:

- **5.2.3.1 Авто зам барих**
- **БА-3.5. Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт**

7. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендерт оролцогч нь дараах хаягаар хандана.

Харилцах ажилтан: Ж.Жижгээ, Худалдан авалтын ажилтан

Гудамж: Чингэлтэй дүүрэг, Анкарагийн гудамж, Тод тауэр барилга

Давхар/өрөөний дугаар: 10 давхар, 1001 тоот

Аймаг/хот: Улаанбаатар хот

Улс: Монгол Улс

Утас: 75093936

Цахим шуудангийн хаяг: procurement.mon3936@gmail.com

8. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендерт оролцогч нь дээр дурдсан хаягт хандан энэ тухай албан хүсэлт гаргаж, үл буцаан олгох нөхцөлөөр тендерийн баримт бичгийн иж бүрдлийг 250,000 (хоёр зуун тавин мянган) төгрөгөөр худалдаж авна. Төлбөрийн нөхцөл нь Төрийн сан банкны MN650090100900011991 тоот дансанд шууд шилжүүлсэн байна.
9. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа **2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Анкарагийн гудамж, 4 дүгээр хороо, Тод тауэр барилга, 10 давхар, 1001 тоот өрөөнд** тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендерийг **2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 10:10 цагт** нээх ба тендерт оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.
10. Захиалагч нь тендерт оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.